



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 06 сарын 06 өдөр

Дугаар А/49

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/379 дугаар захирамж, газрын дүрмийн 2.5.3, 3.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үндэсний түүх, соёл, уламжлалт зан заншлыг сурталчлах зорилгоор Монгол Улсаас Бүгд найрамдах Унгар Улсад суугаа Элчин сайдын яаманд хүргүүлэх иж бүрэн монгол гэрийн судалгаа, үнийн саналыг боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Д.Жавхлан	Мэдээлэл, сурталчилгааны хэлтсийн дарга
Гишүүд:	Б.Тулгаа	Хөгжлийн бодлого хариуцсан мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:	Ш.Ундармаа	Соёлын аялал жуулчлал, салбарын хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

2. Монгол гэрийн судалгаа, үнийн саналыг 2017 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч /Д.Жавхлан/-д даалгасугай.

ДАРГА *D. Batm* Д.БАТСҮХ



1150500198